


## Монгол хөөмий судлал: Өнөөгийн байдал ба хөгжлийн төлөв

**Мөнхжаргалын Амаржаргал** 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,  
Улаанбаатар, Монгол Улс

**Сумьяабазарын Загд-Очир**  

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс  
 [zagdochirsumiyabazar@gmail.com](mailto:zagdochirsumiyabazar@gmail.com)

**Цэрэнбалжирын Цэвэгсүрэн** 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс

**Дамдинсүрэнгийн Даваасүрэн** 

Соёл урлагийн их сургуулийн Театрын урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс

**Хураангуй:** Монгол хөөмий нь дуу авиа, бие махбод, сэтгэлгээний нэгдэл бүхий өвөрмөц соёлын илэрхийлэл бөгөөд ХХ зууны сүүлчээс хойш судлаачдын анхаарлыг татах болсон. Энэхүү өгүүлэлд хөөмийтэй холбогдох судалгааны өнөөгийн байдал, чиг хандлага, тулгамдаж буй асуудал, судалгааны орон зайг монгол болон олон улсын түвшинд харьцуулан тоймлов. Монголд хөөмий судлал нь угсаатны зүй, соёл судлал, урлаг судлал, авиа зүй, боловсролын судалгааны хүрээнд хийгдэж ирсэн ч, мэргэшсэн арга зүй, хөгжмийн онолын гүнзгийрүүлэлт дутагдалтай байдал нийтлэг байна. Харин олон улсын судлаачид хөөмийг акустик, физиологийн механизм, авиа зүйн бүтэц, уламжлал дамжуулалтын хэлбэр, нийгэм-сэтгэлгээний онцлог гэх зэрэг олон өнцгөөс гүнзгий судалсан нь хөөмий судлалын онолын үндсийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулж буйг өгүүлэлд дурдсан. Судалгааны орон зай, цаашдын хэрэгцээг тодорхойлохдоо хөөмийн урын сангийн бүтэц, гүйцэтгэлийн найруулга, орчин үеийн хэрэглээний асуудлыг шинээр тусгах, мөн хөөмийг судлах арга зүйн харилцан уялдаа, олон улсын судалгааны хамтын ажиллагааг эрчимжүүлэх нь чухал болохыг эл өгүүлэлд дүгнэв.

**Түлхүүр үгс:** хөөмий, угсаатны хөгжим судлал, соёлын өв, урын сан, хөгжмийн бүтэц

## Mongolian *Khöömii* studies: Current State and future directions

**Amarjargal Munkhjargal** 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

**Zagd-Ochir Sumyabazar**  

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

 zagdochirsumiyabazar@gmail.com

**Tsevegsuren Tserenbaljir** 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

**Davaasuren Damdinsuren** 

School of Theater Arts, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia.

**Abstract:** Mongolian *khöömii* (throat singing) is a unique vocal tradition that integrates sound production, bodily technique, and cultural expression. Since the late 20th century, it has increasingly attracted scholarly attention. This article provides an overview of the current state of *khöömii* research both in Mongolia and internationally, analyzing major trends, challenges, and research gaps. In Mongolia, *khöömii* has been studied within the frameworks of ethnology, cultural studies, performing arts, phonetics, and education. However, these studies often lack deeper methodological coherence and remain limited to descriptive or illustrative analysis. In contrast, international scholars have approached *khöömii* through diverse perspectives including acoustics, vocal physiology, transmission traditions, and symbolic-cultural meanings, contributing significantly to the theoretical grounding of *khöömii* studies. The article highlights key areas of future research, such as the structure and stylistic development of the *khöömii* repertoire, contemporary adaptations and usage, and the need for interdisciplinary and international collaboration to further develop the field of Mongolian *khöömii* studies.

**Keywords:** *throat singing, ethnomusicology, cultural heritage, Khöömii repertoire, musical structure*

### Оршил

Монгол хөөмий нь хүний хоолойн дотоод бүтэц, амьсгалын урсгал, авиаг уран сайхны түвшинд удирдан, нэгэн зэрэг хоёр буюу түүнээс дээш давтамжийн авиаг ялган илэрхийлдэг өвөрмөц урлагийн хэлбэр юм. Төв азийн нүүдэлчдийн дунд үүсэж, уламжлал, байгаль, шүтлэг, ахуй амьдралтай нягт уялдаж хөгжсөн хөөмий нь XXI зуунд өв соёлын үнэт өв байгаад зогсохгүй, бүтээлч сэтгэлгээний судалгааны шинэ чиглэл болон төлөвшиж байна. Энэхүү хөгжлийн чиг хандлагад судалгааны гүйцэтгэл, агуулгын шинэчлэл чухал үүрэг гүйцэтгэж байгаа боловч, өнөөгийн судалгааны төлөв байдал нь тодорхой хязгаарлалтай хэвээр байна.

Түүхэн талаасаа хөөмийг олон зууныг дамнан уламжлагдсан дуу авианы урлагийн хэлбэр хэмээн үздэг ч, хөгжмийн шинжлэх ухааны хүрээнд хөөмийг харьцангуй “залуу” төрөл (Цэдэн-Иш 2009, 87) хэмээдэг. Ялангуяа түүний полифони шинж, авиа зүйн зохион байгуулалт, хүний биед үүсэх акустик урвалын бүтэц зэргийг судлах онолын хандлагууд сүүлийн жилүүдэд эрчимтэй яригдаж эхэлсэн. Түүнчлэн, хөөмийг “шинжлэх ухааны гоц сонин үзэгдэл” гэж нэрлэсэн судлаачид ч цөөнгүй бөгөөд түүний дотоод логик, авиа зүйн механизм, дамжуулалтын хэв маяг нь хүн судлал, угсаатны хөгжим судлал, дууны онол, авиа зүй, физик, гоо зүй, анагаах ухаан, түүх, соёл судлал, боловсрол судлал зэрэг олон салбарын арга зүйн хүрээнд судлагдах боломжтойг харуулж байна.

Монгол дахь хөөмийн судалгааны эхлэл XXI зууны эхэн үеэс эрчимжиж, угсаатны зүйн болон аман уламжлалын үүднээс хөөмийн гарал, төрөл зүйл, техник, дамжуулалт, урлаг-сэтгэлгээний онцлогийг хөндсөн бүтээлүүд цөөнгүй төрөн гарсан. Тодруулбал, урлаг судлал, соёлын өв, сургалтын хэрэглээ, бие физиологийн баримжаа, физик акустик зэрэг чиглэлээс шинжлэх оролдлогууд эрчимжсэн. Харин олон улс дахь монгол хөөмий судлал 1970-аад оны эхэн үеэс судлаачдын анхааралд өртөж, 1990-ээд оны дунд үеэс Япон, Солонгос, Франц, Герман, Нидерланд, Канад, АНУ, БНХАУ зэрэг улс оронд илүү эрчимжсэн.

Хөгжим судлаач А.Цэдэн-Иш (2003) ОХУ-ын Улан-Үдэ хотод болсон Хөөмийн II симпозиумд танилцуулсан илтгэлдээ гадаадын судлаачдын ихэнх нь монгол хөөмийчдөөс анхлан суралцсан болохыг онцолжээ. Энэ нь хөөмийн дамжуулалтын уламжлал, нэршлийн уялдаа, багш-дагалдагчийн холбоог судалгааны чухал эх хэрэглэгдэхүүн болохыг харуулдаг. Дотоод, гадаадын судлаачид бичгийн болон аман уламжлал, архивын сурвалж, полифонийн онол, авиа зүйн шинжилгээ, бие физиологийн онол зэрэгт тулгуурлан хөөмийн гарал, өвлөн уламжлах арга, уран сайхны бүтээл дэх гүйцэтгэлийн хэв шинж, үүргийг тайлбарлахыг зорьсоор ирсэн. Эдгээр судалгаа нь хөөмийн урын сан бүрэлдэх үндэстэй шууд болон шууд бусаар уялдах, түүнийг задлан тайлбарлах онолын суурь болон хувирчээ.

Ийм нөхцөлд энэхүү өгүүлэл нь монгол хөөмий судлалын өнөөгийн төлөв байдлыг шүүн авч үзэх, түүнийг салбаруудын түвшинд хэрхэн судлагдаж ирснийг харьцуулан тоймлох, судлагдаагүй асуудлуудыг онцлон авч үзнэ. Судалгааны үндсэн зорилго нь хөөмийг зөвхөн уламжлалт соёлын үзэгдэл хэмээн хязгаарлах бус, дотоод бүтэц, уран сайхны зохиомж, гүйцэтгэлийн хэв маяг, бүтээл туурвих онолын боломж бүхий судалгааны нэгэн объект гэж тодорхойлох явдал юм. Энэ утгаар энэхүү өгүүлэл нь хөөмий судлалын өнөөгийн чиг хандлага, хөгжлийн орон зайг эргэн шинжилж, шинэ судалгааны уялдаа, цэгцтэй хөгжлийн шаардлагыг дэвшүүлж буй оролдлого болно.

### **Судалгааны арга зүй**

Энэхүү өгүүлэл нь хөөмий судлалын өнөөгийн төлөв байдлыг шинжлэн дүгнэх зорилгоор баримт бичгийн шинжилгээ (documentary analysis) болон системчилсэн шүүмжийн арга (systematic review)-ыг голчлон ашиглав. Судалгааны үндсэн өгөгдөл нь хөөмийтэй холбоотой монгол, гадаадын хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, ном, диссертац, хурал, чуулганы илтгэлүүд, сургалтын хөтөлбөр зэрэг бичгийн эх сурвалжид тулгуурлана.

Анализ хийхдээ тухайн бүтээлийн судалгааны чиг хандлага, онолын суурь, судлагдсан асуудлын хүрээ, хэрэглэсэн арга зүй, хөөмийн урын сантай хэрхэн холбогдож буй байдлыг харьцуулан авч үзсэн. Мөн бүтээлүүдийн давтамж, судлагдсан асуудлын төвлөрөл, гүйцэтгэлийн талаарх баримт нотолгоо зэргийг харгалзан, хөөмий судлал дахь судалгааны орон зайг илрүүлэхэд анхаарлаа хандуулсан.

### **Судалгааны үр дүн**

#### ***Монгол дахь хөөмий судлал***

Монгол Улсад сайн дурын уран сайханчдын улсын үзлэг болон бүх ард түмний урлагийн их наадам, ардын язгуур урлагийн их наадмуудын хүрээнд олонд танигдаж эхэлсэн хөөмийчдөөс аман сурвалж, ярилцлага авах, дуу болон дүрс бичлэгээр баримтжуулах, хөөмийлөх онцлогийнх нь тухайд олон нийтэд мэдээлэх зорилгоор сонин сэтгүүл, радио, телевизээр сурталчлан таниулах ажлууд хийгдэж эхэлсэн нь судалгааны эхлэл тавигдахад гол нөлөөг үзүүлсэн гэж хэлж болно. Тухайн цаг үед соёл урлагийн салбарт эрдэм шинжилгээний сэтгүүл хараахан гараагүй байхад эрдэмтэн судлаачид өөрсдийн дуу хоолойгоо хурал, чуулган, уулзалт, хэлэлцүүлгүүдэд илтгэх, өдөр тутмын сонин болон танин мэдэхүйн мэргэжлийн сэтгүүлүүдэд нийтлэх зэргээр олон нийтийн хүртээл болгодог байжээ. Түүний нэг жишээ бол ардын билиг зүйч, урлаг судлаач Ж.Бадраа анх 1978 онд Самаркандад зохион байгуулагдсан Олон улсын хөгжим судлаачдын чуулга уулзалтад хөөмий, уртын дууны гайхамшигийн талаар илтгэж, мөн анхны гэгдэх судалгааны шинжтэй нийтлэлийг “Соёл урлаг” танин мэдэхүйн сэтгүүл, “Үндэсний дэвшил” өдөр тутмын сонин, “Утга зохиол, урлаг” сонины хуудаснаа бичиж нийтэлсэн байдаг. Ж.Бадраа, Ж.Энэбиш нарын дэвшүүлсэн санаа, хөөмийн тухай анхдагч судалгааны үр дүн, таамаглалууд эдүгээ улам бүр баяжин гүнзгийрсээр байна. Тухайлбал, Ж.Бадраа:

“Хөөмийлөх<sup>1</sup> урлаг бол аялан исгэрэх урлаг улам бүр хөгжиж өвөрмөц сонин арга барилд шилжсэн дэвшлийн шат бөгөөд хөөмийлөхөд мөн хүний өгүүлэхүйн эрхтэн хөгжмийн зэмсгийн үүрэг гүйцэтгэдэг... ..хэлнийхээ үзүүр, үүдэн шүдээр гоё хөөрхөн нугалаа чимэгтэй ая исгэрэхийн чацуу хөөмийнхөө гүнд үргэлжлэн хүнгэнэсэн дэвсгэр эгшиг дуурьсахын нэр..., хүнгэнэсэн бүдүүн эгшиг нь нарийн эгшиглэх аятайгаа зохиролтой дуурьсгалантай барилдаж байдаг., ...хөгжмийн нилээд нарийн хийцтэй, гишгүүр мэт тусгай төхөөрөмж бүхий зэмсгээр нилээд чадварлаг хөгжимчний хөгжимдөж болох дуурьсамжит давхар аялгууг нэгэн хүн өгүүлэхүйнхээ эрхтний зэргэд ажиллагаагаар гүйцэтгэж байгаад хөөмийлөх урлагийн гайхамшиг оршино” (Бадраа 1998, 46) хэмээн тэмдэглэсэн байдаг бол

<sup>1</sup> Судлаач Ж.Бадраа (1998), Ш.Энхжаргал (2006), Ж.Энэбиш (2007), Б.Одсүрэн (2009), Л.Хэрлэн (2010), М.Амаржаргал (2009), С.Сэрэнбаяр (2019), О.Хийморьт (2023) нарын судалгааны бүтээл, ном, гарын авлагад “хөөмэй, хөөмэйлэх” гэж тэмдэглэсэн эшлэлийг тус өгүүлэлд ашиглахдаа 2018 оноос хойш мөрдөж буй “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-ийг баримтлан “хөөмий, хөөмийлөх” гэж жигдлэн бичив.

хөгжим судлаач Ж.Энэбиш:

“Хэвлийн гүн амьсгалын хүчээр төвөнхийн (хархираа) эгшиг үүсгэх, хэлний үзүүрийг тагнайд шүргүүлж исгэрүүлэх арга хоёрын хослолыг хөөмийлөх гэж нэрлэж болох бөгөөд энэ бүхний үр дүнд хүний хоолойд байж боломгүй өвөрмөц хоёр хоолой нэгэн зэрэг сонсогдох гоц сонин үзэгдэл мөн... ..Ер бусын хоёр хоолойн нэг нь цээжний доргио бүхий хөөмийлэг нам (бүдүүн) эгшиг, нөгөө нь исгэрээ юм., ...гүн хөөмийн исгэрээ нь хатуу тагнайд хэлний үзүүр хүрснээр эгшигийн давхар хугарал үүсгэдэг ажээ. Энэ бол үнэндээ монгол хөөмийн сургалтын үйл ажиллагаа, технологийн нууцыг хэдэн мянганы тэртээд судлан нээчихжээ гэсэн үг юм” (Энэбиш 2007, 216) хэмээн монгол хөөмийн онцлог шинжийг тодорхойлсон байдаг.

Мөн улсын болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдсан хурал, семинар, чуулганд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж, илтгэл танилцуулж ирсэн Б.Одсүрэн, Д.Цэрэндаваа, А.Цэдэн-Иш, Р.Даваажав, Г.Ганцэцэг, Р.Оюунбат, Э.Сандагжав, Ж.Долгорсүрэн, Э.Зулцэцэг, П.Даваапил нарын үе үеийн олон арван судлаач, уран бүтээлч бий. Нийгэм, цаг үеийн өөрчлөлтийг даган мэргэжлийн сургалттай болсноор түүнийг дагаж судалгаа, уран бүтээлийн ажлууд ч улам өргөжин тэлж, эдүгээ Монгол Улсад эрдэм шинжилгээний сэтгүүлд 50 гаруй өгүүлэл нийтлэгдэж, 80 гаруй бакалаврын, 40 гаруй магистрын, 6 докторын судалгаа хийгдээд байна. Тодруулбал, хөөмийн асуудлыг хөндсөн бакалаврын түвшний анхны судалгааг 2003 онд С.Жамьянгаравын нэрэмжит Дорно дахины дээд сургуульд Ч.Бат-Оюун “Монгол хөөмийн урлагийн гарвал зүйн асуудал” сэдвээр, 2008 онд СУИС-д Э.Дүүриймаа “Баруун монгол ардын баатарлаг тууль хөөмийтэй холбогдох нь” сэдвээр, 2009 онд МУИС-д М.Амаржаргал “Монгол хөөмийн авиалбарт хийсэн ажиглалт” сэдвээр гүйцэтгэсэн. Үүнтэй зэрэгцэн 2009 онд анхны мэргэжлийн хөөмийчид СУИС-аас бэлтгэгдэн төгсөхдөө 70% уран бүтээл, 30%-ийн судалгааны бичвэр хийж төгссөн. Түүнээс хойш буюу 2009-2025 оны хооронд СУИС төгсөгчдийн дипломын ажлуудад хөөмийн төрөл ангилал, хөөмийчдийн намтар, уран бүтээл, хөөмийлөх арга барил, ур дүй, газар зүйн тархцын тухайд танин мэдэхүй, практикт чиглэсэн эмпирик судалгаанууд хийгдэх болсон нь сайшаалтай.

Эдгээрээс хөөмийчдийн намтар, уран бүтээл, хөөмийлөх арга барилын талаар Ц.Цогтгэрэл (2009), А.Улаалзгана (2009), Б.Эрдэнэбаатар (2010), Н.Энхтайван (2012), О.Одбаяр (2012), О.Батдорж (2018), Г.Цэдэвдорж (2021), Ү.Чинсайхан (2021), М.Төгсбаяр (2022), н.Энхманлай (2025) нар авч үзсэн бол хөөмийн урын сангийн баяжилт, тэдгээрийг хөөмийлөх ур чадварын тухайд О.Дэлгэрбуян (2012), Д.Басан (2014), М.Алтанцоож (2017), Г.Дэндэв (2017), Б.Баярбаатар (2018), Хай вэн Гуан (2021), М.Төгсбаяр (2022) нар тус тус судалжээ.

Харин магистрын түвшний анхны судалгааг Ш.Энхжаргал (2006) “Монгол хөөмийн төрөл зүйлийн онцлог” сэдвээр хөгжим судлалын хүрээнд судалсан бол, түүний дараа Б.Одсүрэн (2009) “Хөөмийлөх арга барил” сэдвээр, Э.Дүүриймаа (2011) “Монгол аман соёлын зарим хэлбэрүүд, тэдгээрийн харилцан шүтэлцээ” гэх байдлаар судалж эхэлсэн. Энэ мэт монгол хөөмий судлалын магистрын түвшний судалгаа СУИС-д “Хөгжим судлал”, “Соёл судлал”, “Монгол хөөмий”, “Үндэсний язгуур урлаг”, МУИС-д “Урлаг судлал”, МУБИС-д “Урлаг судлал”, “Урлагийн

боловсрол” хөтөлбөрийн хүрээнд судлагдаж байна. Тэдгээр судалгаанд хөөмийн гарал үүсэл, байгалийн шүтэлцээ, төрөл ангилал, нэр томьёо-үгийн гарал, хөг эгшиглэгээ-нот тэмдэглэгээ, газар зүйн тархац, сургалт-заах арга, дэг сургууль, өвлөн уламжлагчдын намтар судлал, уран бүтээл-урын сан, хөөмийлөх арга барил-ур дүй, гүйцэтгэл-хөгжмийн хамсраа зэрэг агуулгууд зарим талаар давхардсан шинжтэй, нарийвчилсан бус байдлаар хийгдсэн байна.

Монгол Улсад хөөмий судлалын анхны докторын судалгааг 2009 онд хийсэн. Л.Хэрлэн (2010) “Монгол хөөмийн утга холбогдол хийгээд дуун ухааны харилцан хамаарал” сэдэвт урлаг судлалын ухааны нэг сэдэвт бүтээлдээ “хөөмий” хэмээх ойлголтыг утга зүйн үүднээс тодруулах, “хөөмий”-н үүтгэлийг домог, түүхэн тэмдэглэлээс сурвалжлах, хөөмийлөх үйлдлийг авиа бүтэх орон, хийн хүрдийн хуваарилалтын үүднээс тодорхойлох, “хөөмийлөх урлаг”-ийг цуурдах, исгэрэх, дуулах урлагийн төрлүүдтэй адилсах болон ялгагдах онцлогийг харьцуулан судлахыг гол зорилгоо болгосон. Харин хөөмийн авиа эгшиглэгээг үүтгэх эх суурь нь амьсгаа хэмээж, хийн хүрд бол амьсгаа авах, тогтоох, хуваарилах зохицуулалтаар авиа үүсгэгч дэг болж, хаана авиа үүсэхээс хамаарч урлагийн төрлүүд ялгагдана; Авиа бүтэх оронд төвөнх, хөөмийн хөндий буюу багалзуур, ам, хамрын хөндий хамаарч тэдгээрийн аль оронд эгшиглэгээ бүтээгдэж буйгаас шалтгаалж хөөмийн төрлүүд бий болно гэдгийг тус тус онцлон дүгнэсэн (Соёл, урлаг судлалын хүрээлэн 2025, 60).

Үүнээс хойш 14 жилийн дараа Монгол Улсад хөөмий судлалын чиглэлээр боловсрол судлал, анагаах ухаан, урлаг судлал, соёл судлалын ухаанаар 5 судалгаа хийгдсэн нь судалгааны том дэвшил болсон.

Судлаач О.Хийморьт (Наймуритай 2024) “Хөөмийлөх ур чадвар: Сургалтын хөтөлбөрийн туршилт, судалгаа (БНХАУ-ын их дээд сургуулиар хөөмийч мэргэжилтэн бэлтгэх бакалаврын хөтөлбөрийн жишээгээр)” сэдэвт боловсрол судлалын докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлдээ “Хөөмийлөх ур чадвар” хөтөлбөрийг боловруулан туршиж, оюутны эзэмшсэн үр дүнг тодорхойлон хэрэгжүүлсэн. Судалгааны хүрээнд хөөмийн авиаг NMR, ENT туршилтаар судалж, хөөмийлөх арга барилын ангиллыг санал болгохын зэрэгцээ их дээд сургуульд хөөмийн мэргэжлийн хичээл ороход хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөрийг хөөмийн багш Б.Одсүрэнгийн аман сурвалж, мэдээлэлд суурилан боловсруулж, 2019-2023 онд БНХАУ-ын Төвийн үндэсний их сургуульд туршин судалсан. Түүний хөтөлбөрийн боловсруулалтад монгол хөөмийн уламжлалт урын санд хамаарах “Гоож Нанаа”, “Дөрвөн уул”, “Дөрвөн настай халиун”, “Цомбон туурайтай хүрэн” гэх зэргийн монгол ардын дуугаар дасгал сургуулилт хийдэг Б.Одсүрэнгийн үзэл баримтлалд суурилсан монгол дахь танхимын сургалтын дэг жаяг, уламжлал (Хийморьт, Байгалмаа 2023, 29) тусгагджээ.

Судлаач Ц.Рэнцэндорж (2024) “Монгол хөөмийн дуу авиа үүсэхэд оролцох эрхтнүүдийн бүтэц, үйл зүйн судалгаа” сэдэвт анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлдээ хөөмийлөхөд оролцох эрхтнүүдийн бүтэц, үйл зүйн онцлогийг анагаах ухааны талаас судалж, хөөмийн төрөл тус бүрийн онцлог ялгааг тодорхойлох зорилгын хүрээнд санамсаргүй түүврийн аргаар 50 хөөмийчийг хамруулж тэдний бие бялдар, эрүүл мэндийн үзүүлэлт, рентген шинжилгээ,

хамар залгиурын уян дурангийн шинжилгээ, спирометрийн шинжилгээ, пульсоксиметрийн хэмжилт, цусны дэлгэрэнгүй шинжилгээ, дуу авиа судлалын шинжилгээнүүдийн үр дүнгээр хөөмийлөх үед залгиурын булчингууд шахагдан бүх хана нь агшиж, төвөнхийн орох амсар хүчтэй нарийсаж, дууны туслах хөвчүүд ачаалж дууны завсар нь нүх шиг болж өөрчлөгдөж буйг тодорхойлжээ. Мөн хөөмий үүсгэхэд оролцох эрхтнүүдийн үйл ажиллагаа нь даралт бүхий агаарын урсгал үүсэх, чичирхийлүүлэн хэлбэлзүүлэх, цуурай үүсгэн хэлбэржүүлэх гэсэн дараалал, уялдаа хамааралтай явагдаж байна хэмээн үзэж, хөөмийн дуу авиа нь бүтцийн оролцоо, үйл зүйн талаасаа шахаа ба хархираа гэсэн хоёр хэлбэрийн дуу гаралтаар үүсэж, уг хоёр төрөлд тулгуурлан бусад хөөмийн авиа хэлбэржин төрөлжиж байгааг анагаах ухааны үүднээс нотолжээ. Хэдийгээр тус ажилд хөөмийн урын сангийн асуудал шууд утгаар дурдагдаагүй ч хөөмийлөх ур чадвар, техникт хамаарах гол хүчин зүйл болох хөөмийн авиа, дуу гаралтын хэлбэрийг анагаах ухааны үүднээс хоёр үндсэн хэлбэртэй болохыг нотолж өгснөөрөө (Rentsendorj et al. 2023, 41) бидний ажилд чухал эх хэрэглэгдэхүүн болно.

Судлаач С.Сэрэнбаяр (2024) “Хөөмий-монголын нүүдлийн хэв шинжит язгуур урлаг болох нь” сэдэвт урлаг судлалын ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлдээ хөөмийн байгальлаг шинж, гарвал зүйг монголын нүүдлийн хэв шинжит орчинтой холбогдуулан авч үзэхдээ хөөмий үүссэн цаг хугацаа, нэршлийг эртний эх сурвалжид тулгуурлан тодруулах, таамаглал дэвшүүлэх, орчин цагийн төлөв байдлыг өвлөн уламжлагчдын аман сурвалжаар судлан тодруулж, дуугаралтын цараа хүрээг лабораторийн туршилт судалгаагаар нотлон харуулахыг эрхэмлэжээ. Судалгааны үр дүнд үгийн нэршлийг монгол язгуурын толиудад үндэслэн “хөөмий” (хөгэмэй) гэж бичих нь зүйтэй, харин хөөмий үүссэн цаг хугацааг “Шо”-ийн магтуу” (НТӨ 660-600) гэх эх сурвалжтай хамаатуулж, “Шо” буюу хоолойн цоор бол хөөмийн хархираатай ойролцоо нэг элемент хэмээн үзжээ. Мөн өвөр монголын Улаанхад хотын Уухань хошууны Шинлингоу (Xinglonggou) гэх дурсгалт газраас олдсон “Хун сан соёл” (Hongshan)-д хамааралтай шавар баримлыг нэрт судлаач Пань Зи Еэ 5300 жилийн өмнөх үед хамаарах “хөөмийлж буй хүний баримал” гэж тогтоосон тухай өгүүлжээ. Энэ мэт хэд хэдэн баримт, эх сурвалжийг дурдаж, түүндээ тулгуурлан “монголчууд XVIII зууны үед хөөмийг Тувагаас зээлдэн авсан...” гэсэн үзлийг няцааж, хөөмий үүссэн цаг үеийг НТӨ үе рүү урагшлуулан тооцох боломжтой (Сэрэнбаяр 2024, 42) хэмээн үзсэн. Хэдийгээр хөөмий төст авиа эгшгийг хүн төрөлхтөн эрт үед гаргаж эхэлснийг “Шо”-ийн магтуугийн эх сурвалжид хамаатуулан үзэх боломжтой ч “Хун сан соёл”-д хамааралтай гэх баримлыг үнэхээр хөөмийлж байсан хүн үү? гэдгийг нягтлан шинжлэх шаардлагатай (Соёл, урлаг судлалын хүрээлэн 2025, 76).

Судлаач Э.Дүүриймаа (2024) “Хөөмийлөхүй, хайлахуйн харилцан шүтэлцээ” сэдэвт соёл судлалын ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлдээ хөөмийлөхүй, хайлахуйн түүхэн хөгжил, төрөл зүйлийн онцлог, харилцан хамаарлыг судлахдаа бүтэц, үйлийн онцлог, тэдгээрийн нийтлэг болон ялгаатай талыг тодруулан судалсан. Ингэхдээ хөөмийлөхүйн үйлийг түүхэн мэдээлэл болон илэрхийлэх арга хэлбэрийн хувьд урлагийн хэв шинжийг илэрхийлдэг ч нөгөө талаас анх үүссэн үүрэг, зориулалтын үүднээс авч үзвэл, зан үйл, утга бэлгэдэл

бүхий соёлын үзэгдэл болж байгаагаар онцлог хэмээсэн. Мөн хөөмийлөхүйн үйлийг хорио цээрийн болон засал домын шинжийг агуулсан эртний цалиг шүтлэгийн хэв шинжит соёлын өв хэмээгээд хүн, байгаль, амьтан гурвын шүтэн барилдахуйгаас үүссэн, эртний түүхэн мэдээллийг аман аргаар аялгуулан илэрхийлэх бие, хэл, сэтгэлийн урлахуйн үйл (Дүүриймаа 2024, 79) хэмээн тодорхойлсон. Үүнчлэн, түүхэн хэрэгцээ шаардлага, илэрхийллийн арга технологийн үүднээс шахаа, исгэрээ, хархираа гэсэн гурван үндсэн төрөлтэй хэмээн үзсэн. Эцэст нь хөөмийлөхүй, хайлахуйн үйл нь гарал үүслийн хувьд харилцан хамааралтай үүсэн хөгжиж, улмаар өөр хоорондоо уялдан зохирч оршдог монголчуудын зан заншил, зан үйл, утга бэлгэдэл, сүсэг бишрэл, ертөнцийг үзэх үзэл, танин мэдэхүй, гоо сайхан, урлагийн таашаал, мэдрэмжийн илрэл, соёлын цогц илэрхийлэл, үзэгдэл болон өөр өөрсдийн бие даасан хэлбэрээр хөгжиж буйг дүгнээд, хөгжлийн энэ явцдаа төрөлх унаган хэлбэрээрээ Алтайн нуруу даган нутаглах зон олны дунд өвлөн уламжлагдсан байж болзошгүйг цохон тэмдэглэсэн (Соёл, урлаг судлалын хүрээлэн 2025, 151).

Судлаач Бүргэд (Burigede 2025) “Монгол хөөмийн сургалтын арга зүйн судалгаа, туршилт, үр дүн (БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хишигтэн хошууны Монгол дунд сургуулийн 13-17 настай сурагчдын жишээн дээр)” сэдэвт боловсрол судлалын докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлдээ монгол хөөмийн үүсэл, хөгжил, хөөмийн ангиллыг тоймлон мэлээлж, уламжлалт арга барилын онцлог хийгээд сургалтын үзэл баримтлал, монгол хөөмийд суралцах шинэлэг арга зүйг туршилт судалгаагаар батлан харуулсан.

Эдгээрээс гадна хөөмийн талаар өгүүлсэн цөөн боловч нягтлан үзүүштэй хэд хэдэн ном, гарын авлага хэвлэгдсэний дотор хөөмийч, дуучин Э.Сандагжав (2010)-ын “Монгол хөөмий” бүтээлд хөөмийн түүх, төрөл зүйл, хөөмийг хэрхэн зааж сургах талаар өгүүлж, ахмад үеийн хөөмийчдийн товч намтрыг багтааснаараа онцлог. Л.Хэрлэн (2010)-ийн “Монгол хөөмийн утга холбогдол” бүтээл нь докторын диссертацийн нэг сэдэвт судалгааны үр дүн юм. Д.Мягмаржав (2015)-ын “Ая эгшгийн охь манлай” бүтээл хөөмийн урлаг тархан хөгжсөн өлгий нутаг болох Ховд аймгийн Чандмань сумын түүхт 90 жилийн ойд зориулсан, тус нутгаас төрсөн алдарт хөөмийчдийн үүх түүх, тэдний хөөмийлөх онцлогийн тухай зураг, дурсамжийг багтаасан. С.Сэрэнбаяр (2019)-ын “Монгол хөөмий” бүтээлд хөөмийн шинж, бүтэц, үүрэг, хөөмийд суралцах арга зүйн судалгааг авч үзсэн бол Д.Нямдорж, С.Энэбиш, Ц.Рэнцэндорж Б.Журамт нар (2020)-ын “Монгол хөөмий судлал” бүтээлд хөөмийлөхөд оролцох эрхтний бүтэц, судалгааны тойм, хөөмийлөх эрхтнүүдийн бүтэц-үйл зүй, дуу хоолойн эрүүл мэндийн асуудлыг онцлон тусгаснаараа онцлогтой. Харин нэрт хөөмийч Нанжидын Сэнгэдоржийн амьдрал, ажил үйлс, уран бүтээл, хувийн тэмдэглэл, гар бичмэлийг багтаасан “Хөөмийгөөр хөглөгдсөн амьдрал” бүтээлийг Б.Гиймаа (2023) эмхэтгэсэн.

#### ***Олон улс дахь монгол хөөмий судлал***

Монгол хөөмий нь сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд дэлхийн олон орны судлаач, хөгжмийн онолч, угсаатны зүйчдийн сонирхлыг татсан сэдэв болоод байна. Олон улсын эрдэмтэн судлаачид монгол хэлний “хөөмий” (уйгаржин монгол бичгээр “хөгэмэй”) гэх нэршлийг “*chöomei*” (Aksenov 1964), “*khöömi*” (Bosson 1964),

“*hömi*” (Vargyas 1968), “*chöömij*” (Vietze 1969), “*xöömij*” (Hamayon 1973; Trân 1978), “*khöömei*” (Nixon 1989), “*xöömii*” (Pegg 1992) гэх зэргээр галиглаж ашиглахаас гадна “*biphonic singing*”, “*split-tone singing*”, “*throat singing*”, “*chant biphonique*”, “*voix dédoublée*”, “*Jew’s harp voice*” гэх мэт нэр томъёог ашиглаж ирсэн нь хөөмийн бүтэц, дуурьсал, дотоод полифонийг тодорхойлох оролдлогууд юм (Pegg 1992, 31).

Хөөмийн олон улсын судалгаанд анхлан томоохон хувь нэмэр оруулсан хүмүүсийн нэг бол францын судлаач Тран Куан Хай юм. Тэрээр 1960-1970-аад онд Роберт Амайоны Монголд хийсэн хээрийн судалгааны бичлэгүүдийг анализ хийж, психоакустик ба сонографын арга зүйгээр хөөмийн авианы спектр, резонансын бүтцийг судалсан (Tran, Guillou 1980). Харин нидерландын угсаатны хөгжим судлаач Марк ван Тонгерен “*Overtone singing*” бүтээлээ хөөмийг зөвхөн дууны техниктэй холбох бус, танин мэдэхүйн, философи сэтгэлгээний бүтцийн үүднээс тайлбарласан (Tongereren 2013, 128). Түүний судалгааны хэрэглэгдэхүүнд тува болон монгол хөөмий, Алтай-Кай, Хакас, Башкир, Өмнөд Африкийн ижил төстэй гармоник аялгуунууд багтсан бөгөөд Хюго Земп, Тран Куан Хай нарын судалгаанаас санаа авч өөрийн судалгааг нарийвчлан хөөмий болон хөөмий төст дуу чимээ, чичиргээний мөнхийн бөгөөд түгээмэл талуудыг тайлбар, график дүрслэлүүдээр үзүүлснээрээ онцлог.

Францын эрдэмтэн Ален Дежак “Хоёр дуугаргалттай (дихоник) монгол хөөмийн онцлогийг хөгжмийн болон байгаль-амьтны орчны харилцан хамаарлын хүрээнд авч үзэх нь хамгийн боломжтой арга зам...” (Desjacques 1990, 106) хэмээсэн бол Кэмбрижийн их сургуулийн эрдэмтэн Карол Пэгг (1992) нь дуу авианы өөрийнх нь акустик болон физиологийн шинжилгээнд гол анхаарлаа хандуулж, нүүдэлчдийн сэтгэлгээ, байгаль-сүнслэг орчин, бөө мөргөл, урлагийн зан үйлтэй уялдуулан тайлбарласан. Тэрээр хөөмийн дамжуулалт, нэршил, гүйцэтгэлийн нөхцөл уламжлалын түүх зэргийг гүн судалсан нь өнөөгийн монгол хөөмий судлалын цөөнгүй судалгаанд суурь болохуйц нөлөө үзүүлсэн.

Японы судлаачид, тухайлбал, Ямада Масаши (1995), Сэжи Адачи (1997), Терио Мараока, Масаказу Такеда, Масаши Итога (2000) нар хөөмийн физиологийн бүтэц, дууны замын MRI дүрслэл, амны хөндийн хэлбэржилт, хэлний байрлал зэрэгт суурилсан техникийн судалгаа хийсэн (Adachi, Yamada 1999, 2928). Мөн судлаач Кондо Казумаса (1999) хөөмийлөх механизм, резонансын болон дуу үүсэх зохицуулалт, хөөмийн хүчний спектр зэргийг монгол хэлний эгшиг болон зарим гийгүүлэгч авианы хэлэгдэх бүтэцтэй харьцуулан спектрограмын шинжилгээ хийсэн. Тэгвэл До Хён Нам, Жэ Чин Пайк, Ён Шин Ван нарын солонгос судлаачид монгол хөөмий нь тувагийн сыгыт болон каргираа хэв маягийн адил хэмээн тэмдэглээд дууны нугалмын давтамж, цахилгаан долгионы хэлбэр зэргийг монгол хэлний “а, э, и, о, у” эгшиг авиануудад тулгуурлан шинжилсэн (Nam et al. 2008, 149). Мөн До Хён Нам, Жэ Чин Пайк, Ён Шин Ван нар хөөмийг дууны нугалмын давтамж, авианы хэлбэртэй холбон тайлбарласан.

Монголын хөгжим судлаачдын дундаас хамгийн анх хөөмийг гадаад оронд судалж эхэлсэн хүн бол Г.Ганцэцэг бөгөөд тэрээр ОХУ-д “Монгольское двухголосное гортанное пение” (Монгол хөөмий) (1992) сэдвээр бакалаврын түвшний бүтээл туурвисан нь монгол хүн өөрийн уламжлалаа шинжлэх ухаанд

таниулах алхмыг хийсэн чухал жишээ юм. Мөн хөгжим судлаач Ж.Энэбиш, А.Цэдэн-Иш, Э.Сандагжав нар хөөмийн уламжлал нэршил, гүйцэтгэл, хөгжлийн үүднээс тодорхойлох судалгаа хийсэн ч тэдгээр нь илүү нийтлэлийн болон лекцийн хэлбэртэйгээр тархсан байдаг.

Францын угсаатны хөгжим судлаач Жоанни Кюртэ (2013) “Хоолойн өнгөний урлаг болох хөөмийн өвлүүлэлт: Монгол хөөмийн түүх, угсаатны хөгжим судлал” сэдвээр Рэннэ-2 их сургуульд докторын зэрэг хамгаалсан. Тэрээр хөөмийн уламжлал, дамжуулалт, өнгө, академик тайзны өөрчлөлтийн талаар онолын гүнзгий тайлбар хийж, “хөөмийн үндсэн мөн чанар нь өнгө (тембр)” болохыг онцолсон (Curtet 2013, 145) нь олон улсын судалгаанд шинэ хандлага авчирсан.

БНХАУ-ын судлаачид хөөмийг бие махбодын механизм, акустик бүтэц, цоор дуу-хөөмийн харилцан шүтэлцээ, бүс нутаг дамжин хөгжсөн уламжлалын асуудлыг судалж байна. Тухайлбал, Фу Жиан Шинь (傅建鑫 2013), Гуан Ян Мэй (关杨美 2013), Жан Янань (张亚楠 2020), Цай Нин (蔡宁 2023) нарын судалгаанд Өвөр монгол дахь хөөмийн хөгжлийн орчин үеийн хандлага, бүс нутгийн онцлог, өв уламжлалын үндэсний цөөнхийн соёлын нэгэн хэсэг болох талаас нь авч үзжээ.

Мөн АНУ, Канад, Турк зэрэг орнуудын судлаачид хөөмийн тухайд тусгайлсан онолын болон харьцуулсан судалгааг явуулсан. Тухайлбал, туркийн Волкан Саклаян хөөмийг “сүнслэг зан үйл, нийгмийн үнэт зүйлсийг дамжуулагч урлаг...” (Çağlayan Volkan 2014, 5) хэмээн тодорхойлсон байдаг. Үүнээс гадна Иллионы их сургуулиас эрхлэн гаргасан “Mongolian Sound of World” (2022) бүтээлд Андрей Колвел (Andrew Colwell), Жоанни Кюртэ (Johanni Curtet) нар монгол хөөмийн хоёр талт асуудлууд, түүний талаарх аман сурвалжууд, мөн монгол хөөмийн өнөө ба ирээдүйн асуудлыг хөндөн авч үзсэн.

Эдгээр олон улсын судалгаанууд нь хөөмийн авиа бүтцийн шинж, гүйцэтгэлийн техник, уламжлалын хэлбэржилт, дамжуулалтын орчин, сэтгэлгээний суурьтай гүн уялдаатай гэдгийг баталж байгаа юм. Түүнчлэн, дээрх судалгааны олонх нь тува болон монгол хөөмийг зэрэг авч үздэг боловч монгол хөөмийг тусгайлан онцолсон бүтээлүүд цөөн бөгөөд үүний цаана монгол хөөмий судлалын тусгаар, бие даасан судалгааны чиглэлээр хөгжих зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

### ***Судалгааны орон зай ба цаашдын чиг хандлага***

Монгол хөөмий нь ХХ зууны дунд үеэс хойш олон улсын судлаачдын анхааралд өртөж, дуу авианы хосолмол бүтэц, биеийн физиологийн онцлог, соёлын өвийн хувьд сонирхол татахуйц объект болон төлөвшсөн хэдий ч хөөмий судлалын цогц бүтэц, системчлэл одоог хүртэл бүрэн төлөвшөөгүй хэвээр байна. Монгол хөөмийг үндэснийх нь соёл, уран сайхны сэтгэлгээ, хэлний онцлог, уламжлалт хэрэглээ, урын сангийн бүтэцтэй нь уялдуулан судлах орон зай байна. Иймээс хөөмий судлалын цаашдын хөгжилд дараах чиглэлүүд онцгой ач холбогдолтой хэмээн санана. Үүнд:

- Монгол хөөмийг бусад үндэстэн угсаатны ай савын уламжлалтай харьцуулж, язгуур гарал, түүхэн хэлбэржилт, дууны хэв маягийн ялгааг тодорхойлж, угсаатны хөгжмийн судалгааг гүнзгийрүүлэх;
- Монгол хөөмийн урын сангийн бүрдэл, түүний дотоод зохион байгуулалт буюу бүтээлийн найруулгын бүтэц, хэлбэр, ритм, хэмнэл, обертон,

- тембрийн логик уялдаа, төрөл зүйл, нэршил зэргийг хөгжмийн онолын үүднээс системтэй шинжлэх;
- Хөөмийн бүтээлийг түүхэн үе, гүйцэтгэлийн нөхцөл, хэрэглээний орчин, технологийн хөгжилтэй уялдуулан уламжлал ба орчин үеийн шинэ бүтээлийн харьцуулалт, хөөмийлөх арга барилын өөрчлөлт, хөгжмийн хамсрааны уялдаа, уламжлалын трансформацыг судлах;
  - Аман болон биеийн хэлээр дамжуулах арга барил, багш-дагалдагчийн харилцаа, сургах арга зүйг онолын түвшинд судлах нь сургалт, боловсролын салбарт чухал үр нөлөөтэй. Дамжуулалтын үе шат, сэтгэлгээний хэв маяг, заах-сурах онцлогийг задлан тайлбарлах. Үүнчлэн, мэргэжлийн болон уламжлалт сургалтын агуулга, боловсролын хөтөлбөрийн үнэлгээ, сургалтын үр дүнг тодруулах;
  - Дижитал технологийн интеграц, цахим орчин дахь бүтээлч хэрэглээ, спектрограмм, MRI, өндөр нарийвчлалтай акустик шинжилгээ, нейросинтез зэрэг шинжлэх ухааны дэвшилтэт арга зүйгээр дахин судлах шаардлага бий.

### Хэлэлцүүлэг

Монгол хөөмий судлал нь дуу авиа, бие махбодын физиологи, соёлын өвийн утга зүй, урлагийн сэтгэлгээ зэрэг олон түвшний судалгааг хамрах боломжтой цогц судлагдахуун боловч Монгол Улсын академик орчинд бие даасан судалгааны салбар болон бүрэн төлөвшөөгүй байна. Өнөөг хүртэл судалгааны бүтээлийн дийлэнх нь уламжлал, үүсэл гарвал, шүтлэгийн үзэл зэргээр тайлбарлах түвшинд төвлөрч, хөөмийн дуугаралтын бүтэц, гүйцэтгэлийн хэв шинж, уламжлалын өөрчлөлт, шинэ бүтээлийн хэлбэр зүй зэрэг асуудал харьцангуй сул хөгжсөн хэвээр байна.

Монгол дахь хөөмий судлалын өнөөгийн байдлыг авч үзвэл угсаатны зүй, соёл судлал, урлаг судлал, авиа зүй, боловсрол судлалын салбаруудад хийгдсэн анхны суурь судалгаанууд бий болсон нь харагдана. Гэвч эдгээр судалгааны олонх нь салбарын мэргэшсэн онол-арга зүйн хүрээнд бүрэн гүнзгийрсэн гэхээс илүүтэй, танин мэдэхүйн шинжтэй тайлбар давамгайлах хандлагатай байна. Иймээс хөөмий судлалыг шинжлэх ухааны нарийвчилсан судалгааны түвшинд боловсруулах нөөц боломж нээгдсээр байна гэж үзэж болно.

Харин олон улсын судалгаанд монгол хөөмийтэй холбогдох акустик судалгаа, физиологийн хэмжилт, спектрал анализ, соёлын утга зүйн тайлбар зэрэг нь өндөр түвшинд хөгжиж, хөөмийг бие махбод, зан үйл, урлагийн цогц үзэгдэл болгон авч үзэж байна. Гэсэн хэдий ч эдгээр судалгааны ихэнх нь монгол хөөмийг төв объект бус, харьцуулалтын жишээ хэлбэрээр авч үзсэн тул монгол уламжлалыг нарийвчлан судлах талбар бүрэн нээлттэй хэвээр байна.

Иймээс хөөмий судлалын цаашдын хөгжилт хөөмийлөх арга барил, авиа зүйн бүтэц, бүтээлийн төрөл зүйл, уламжлалын дамжуулалт болон орчин үеийн нийгэм-технологийн өөрчлөлтөд дасан зохицох үйл явцыг хамарсан интердисциплинар судалгаа шаардлагатай байна. Нөгөө талаар дотоодын эрдэм шинжилгээний байгууллагуудад хөөмийд чиглэсэн судалгааны бодлого, сургалтын хөтөлбөр,

өгөгдлийн сан, баримтжуулалтын арга зүйг бүрдүүлэх хэрэгцээ улам бүр тодорч байна.

### Дүгнэлт

Монгол хөөмий нь дуу авианы бүтэц, хөөмийлөх арга барил, уран сайхны илэрхийлэл, соёлын хэрэглээ зэрэг олон талын шинжийг агуулсан, судалгааны өргөн боломжтой өвөрмөц соёлын үзэгдэл юм. Хэдийгээр хөөмийтэй холбогдох судалгаанууд нийгэм-хүмүүнлэгийн ухааны хэд хэдэн салбарт хийгдэж ирсэн ч, эдгээр судалгааг нэгдсэн онол-арга зүйн хүрээнд системтэйгээр нэгтгэн хөгжүүлэх шаардлага байсаар байна.

Ялангуяа хөөмийн уламжлал ба урын сангийн тогтолцоог бүтцийн үүднээс авч үзэх, өөрөөр хэлбэл, урын сангийн бүрэлдэхүүн, дэг сургалтын уламжлал, гүйцэтгэлийн хэв шинж, шинэ бүтээлийн хөгжлийн зүй тогтлыг харилцан уялдаатайгаар шинжлэх судалгаа хангалттай хөгжөөгүй хэвээр байна. Иймээс монгол хөөмийг зөвхөн дуу авианы үзэгдэл бус, уламжлал-шинэчлэлийн харьцаанд тэнцвэржин хөгждөг уран сайхны тогтолцоо хэмээн авч үзэх онол-практикийн судалгаа цаашдын хөгжлийн гол чиглэл байх шаардлагатай юм.

Энэхүү өгүүллээр монгол хөөмийн судлалын өнөөгийн байдлыг тоймлон харуулж, судалгааны нээлттэй орон зай үлэмж байгааг тэмдэглэсэн нь цаашид хөөмийг онолын сууртай, харьцуулсан болон эмпирик судалгааны аргаар нарийвчлан судлах, түүнчлэн олон улсын судалгааны сүлжээнд илүү идэвхтэй нийтлэх нь зүйтэй гэдгийг онцолж байна.

### Ашигласан материалын жагсаалт

#### **Монгол хэлээр:**

Бадраа, Жамц. 1998. *Монгол ардын хөгжим*. Улаанбаатар: Т&У принтинг.

Бүргэд (Burigede). 2025. “Монгол хөөмийн сургалтын арга зүйн судалгаа, туршилт, үр дүн (БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хишигтэн хошууны Монгол дунд сургуулийн 13-17 настай сурагчдын жишээн дээр).” Боловсрол судлалын докторын зэрэг горилсон бүтээл. Монгол Улсын Боловсролын их сургууль.

Гиймаа, Балжинням. 2023. *Хөөмийгөөр хөглөгдсөн амьдрал. (Н.Сэнгэдоржийн амьдрал үйлс, дурсамж тэмдэглэл, зураг, уран бүтээл)*. Улаанбаатар.

Дүүриймаа, Эрдэнэцогт. 2024. “Хөөмийлөхүй, хайлахуйн харилцан шүтэлцээ.” Соёл судлалын докторын зэрэг горилсон бүтээл. Соёл урлагийн их сургууль.

Мягмаржав, Довчин. 2015. *Ая эгшгийн охь манлай*. Улаанбаатар: Сэлэнгэпресс ХХК.

Нямдорж, Дагданбазар., Энэбиш, Сундуй., Рэнцэндорж, Цагаанхүү., Журамт, Болд. 2020. *Монгол хөөмий судлал*. Улаанбаатар: Сэлэнгэпресс ХХК.

Рэнцэндорж, Ц. 2024. “Монгол хөөмийн дуу авиа үүсэхэд оролцох эрхтнүүдийн бүтэц, үйл зүйн судалгаа.” Анагаах ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Анагаахын шинжлэх ухааны их сургууль.

- Сандагжав, Э. 2010. *Монгол хөөмий*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Соёл, урлаг судлалын хүрээлэн. 2025. *Монгол Улсад соёл, урлаг судлалын докторын зэрэг хамгаалсан бүтээлийн тойм. 1978-2024*. Улаанбаатар: Адмон принт ХХК.
- Сэрэнбаяр, Сэрэнноров. 2019. *Монгол хөөмий*. Улаанбаатар.
- Сэрэнбаяр, Сэрэнноров. 2024. “Хөөмий-Монголын нүүдлийн хэв шинжит язгуур урлаг болох нь.” Урлаг судлалын докторын зэрэг горилсон бүтээл. Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Хийморьт, Отгонбаатар., Байгалмаа, Чүлтэм. 2023. “Хөөмийлөх ур чадвар” *сургалтын хөтөлбөр*. Ред. Хэрлэн Р. Улаанбаатар: Өөдрөг өнгө ХХК.
- Хийморьт (Наимуритай), Отгонбаатар. 2024. “Хөөмийлөх ур чадвар” сургалтын хөтөлбөрийн туршилт судалгаа (БНХАУ-ын их дээд сургуулиар хөөмийч мэргэжилтэн бэлтгэх бакалаврын хөтөлбөрийн жишээгээр).” Боловсрол судлалын докторын зэрэг горилсон бүтээл. Монгол Улсын Боловсролын их сургууль.
- Хэрлэн, Л. 2010. “Монгол хөөмийн утга холбогдол хийгээд дуун ухааны харилцан хамаарал.” Урлаг судлалын докторын зэрэг горилсон бүтээл. Монгол Улсын их сургууль.
- Хэрлэн, Л. 2010. *Монгол хөөмийн утга холбогдол*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Цэдэн-Иш, А. 2009. “Хөөмийн урлагийн нэршлийн зарим асуудалд.” *Хөгжим*. Улаанбаатар: Gcom press.
- Энэбиш, Ж. 2002. “Монголын модон цуур болон хөөмийн гарал үүслийг хятадын эртний сурвалж бичгийн мэдээтэй харьцуулсан судалгаа.” *Олон улсын монголч эрдэмтдийн VIII их хурлын илтгэл. Уран сайхны шүүмж буюу онгодыг өдөөгч “халгай”*: 211-218. Улаанбаатар.
- Гадаад хэлээр:**
- Adachi, S. & Yamada, M. 1999. “An acoustical study of sound production in biophonic singing.” *Xөөмий Journal of Acoustic Society America*. 105(5): 2920-2932.
- Andrew Colwell and D.Tserendavaa. 2022. “Interlude: Everything Has Two Sides: An Interview.” *Mongolian Sound Worlds*: 197-202.
- Carole Pegg. 1992. “Mongolian conceptualisations of overtone singing (хөөмий).” *British Journal of Ethnomusicology*. Vol.1: 31-54.
- Çağlayan, Volkan. 2014. “Khömmei Vocal Techniques in a Study of the Bard Tradition in Mongolia.” *DAKAM Proceeding Musicult '14*.
- Curtet, J. 2013. “La transmission du höömij, un art du timbre vocal: ethnomusicologie et histoire du chant diphonique mongol.” Doctoral dissertation. Rennes 2 University, France.

- Desjacques Alain. 1992. “Chants de l’Altaï mongol.” Thèse de doctorat nouveau régime sous la direction du Prof. Manfred Kelkel et du Prof. Jacques Legrand. Paris: Paris IV-Sorbonne, 389 p. avec 1 cassette audio.
- Johanni Curtet. 2022. “handman’s and Beyond: Heritage-making of Mongolian Khöömii in Past and Present.” *Mongolian Sound Worlds*: 203-226.
- Nam Do-Hyun, Paik Jae-Yeon, Hwang Yoen-Shin, Choi Hong-Shik. 2008. “Analysis of Singing Technique of Mongolian Traditional Singing Called Khoomei.” *Korean Society of Speech Sciences*, Volume 15, Issue 3: 145-156.
- Tran Quang Hai, Guolou D. 1980. “Original Research and Acoustical Analysis in Connection with the Xöömij Style of Biphonic Singing.” *Musical Voices of Asia*: 162-173.
- Rentsendorj, Tsagaankhuu., Ganchimeg, Palamdorj., Byambasuren, Luvsandagva., Nyamdorj, Dagdanbazar. 2023. “The Anatomical and Physiological Basis of the Mongolian Khuumii.” *Central Asian Journal of Medical Sciences*. Mar; 9(1): 36-41. <https://doi.org/10.24079/cajms.2023.03.005>
- Tongeren, Mark Christian van. 2013. “Overtone singing: Harmonic Dimensions of the Human Voice.” Leiden University dissertation, the Netherlands. Retrieved from <https://hdl.handle.net/1887/20611>.
- 山田真司. 1998. 一人で歌う＝重唱－モンゴルのホーミー－. 日本音響学会誌 54 卷 9 号: 680-685. (Masashi Yamada. 1998. Singing alone-Mongolian’s Xöömij. *Journal of the Acoustical Society of Japan*, Vol. 54, No. 9: 680-685.)